МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2023 оны 04 сарын 18 өдөр Дугаар А/132 Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

"МУБИС-ийн дүрэм"-ийн 4.4.1, Дотоод журмын 4.2 дах хэсгийн 4.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Боловсролын их сургуульд ажилтан сонгон шалгаруулж авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Тамгын газрын дарга
Нарийн бичгийн дарга: Хүний нөөцийн менежер
Гишүүд: Сургалт хамтын ажиллагааны газрын дарга
Эрдэм шинжилгээ, инновацын газрын дарга
Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга
Тухайн ажлын байрны захиалга өгсөн Бүрэлдэхүүний сургуулийн захирал, тэнхимийн эрхлэгч, хөтөлбөрийн албаны дарга, (сургалтын менежер)
Гадаад харилцааны албаны дарга

2. Бүрэлдэхүүний сургууль, алба нэгжээс ирүүлсэн ажлын байрны захиалгад үндэслэн нээлттэй сонгон шалгаруулалт зарлах, бүртгэх, сонгон шалгаруулах удирдамжийг хавсралтаар баталсугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын дарга (Л.Мөнхтуяа)-д үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ Ж.БАТБААТАР

9087702 ак 9021051159

Tushaal.doc

МУБИС-ийн Захирлын 2023 оны ..4..дүгээр
сарын ..18..-ны өдрийн ..А/132.. дугаар
тушаалын 1 дүгээр хавсралт

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛЬД
АЖИЛТАН СОНГОН ШАЛГАРУУЛЖ АВАХ АЖЛЫН УДИРДАМЖ

Зорилго: МУБИС-ийн Удирдах зөвлөлөөс батлагдсан ажлын байр /албан тушаал/-ын дагуу ажиллах хүсэлтээ илэрхийлсэн иргэний хүсэлтийг хууль тогтоомж, дүрэм, журмын хүрээнд шийдвэрлэх ажлыг зохион байгуулах.

Хамрах хүрээ: МУБИС-ийн Тамгын газар, Бүрэлдэхүүний болон салбар сургууль, дэргэдэх нэгжүүд хамаарна.

Хийгдэх ажил:

1. Тамгын газар, Бүрэлдэхүүний болон салбар сургууль, дэргэдэх нэгжүүдээс ажлын байрны захиалгыг авах
2. Захиалгын дагуу ажлын байрны нээлттэй сонгон шалгаруулалтыг зарлаж бүртгэх
3. Батлагдсан ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолтод тавигдах нийтлэг шаардлагын дагуу холбогдох баримт, материалыг ажлын хэсгийн хурлаар хэлэлцэн тухайн ажлын байранд тавигдах шаардлагыг хангаж байгаа байдалд үнэлэлт, дүгнэлт хийх
4. Ажил горилогчийг нэгжийн болон ажлын хэсгийн ярилцлагад оруулж, шаардлагатай тохиолдолд хэлний болон нарийн мэргэжлийн шалгалтыг авах
5. Ажлын хэсгээс гаргасан үнэлэлт, дүгнэлтийг МУБИС-ийн захирал болон Захиргааны зөвлөлийн хуралд танилцуулах
6. Эрдмийн зэрэг цолтой, ажлын туршлагатай иргэнийг урилгаар авч ажиллуулж болно. Энэ тохиолдолд шууд Захиргааны зөвлөлийн хуралд танилцуулах
7. Захиргааны зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн тухайн ажлын байранд томилох, удирдах албан тушаалд томилохоор Авлигатай тэмцэх газарт холбогдох материалыг хүргүүлэн тус газрын дүгнэлтийг үндэслэн томилгоо хийх тушаал гаргах
8. Тухайн ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулж, ажлын байрны тодорхойлолт, холбогдох дүрэм журмуудыг танилцуулах
9. Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга нь сонгон шалгаруулалтын материалыг бүрдүүлэн ажилтны мэдээллийн санд баяжилт хийх буюу архивд холбогдох журмын дагуу шилжүүлэх